



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
АЛБАН ДААЛГАВАР

2021 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар
тахлын тархалтыг хумих хариу арга хэмжээг
сайжруулах, халдвар хамгааллын дэглэм,
ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай

Коронавируст халдвар (КОВИД-19) хүн амын дунд тархаж Гамшгаас хамгаалах тухай хуульд зааснаар бүх нийтийн бэлэн байдал “Улаан түвшин”-д шилжүүлсэнтэй холбогдуулан хүн амыг халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор Улсын онцгой комиссоос зохион байгуулалтын шуурхай хариу арга хэмжээ авч ажиллаж байна.

Улсын онцгой комиссоос хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэрийг бүх шатанд хэрэгжүүлэх, халдварын тархалтыг өргөн хүрээнд хумих зорилгоор Аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комиссын гишүүд, яам, агентлагийн дарга нарт Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг тус тус үндэслэн ДААЛГАХ нь:

Нэг. Аймаг, нийслэлийн Онцгой комиссын гишүүдэд:

1.1. Гамшгаас хамгаалах удирдлагын төв /Шуурхай штаб/-ийн үйл ажиллагааг сайжруулах, цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг биечлэн хянаж зохион байгуулах, удирдлагын тогтолцоог бие даан хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх,

1.2. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулах, сум дүүрэг, баг хороодод халдвар хамгааллын хатуу дэглэмийг нэг сарын хугацаанд мөрдүүлж, иргэд, холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах,

1.3. Алслагдсан сум суурин, өрх айл, баг хорооны иргэдэд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ хүрэхгүй байх, хариу арга хэмжээ тасалдах, улмаар мал амьтанд халдварт өвчин халдварлаж болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж Аймаг, нийслэл, баг, хороо, сум дүүргийн хооронд иргэдийн болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах,

1.4. Иргэдийг дархлаажуулалтад бүрэн хамруулах ажлын төлөвлөгөөг орон нутгийн онцлогтой уялдуулж 2021 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн дотор нарийвчлан шинэчлэх, дархлаажуулах байр, хүйтэн хэлхээ, дархлаажуулах багийг бэлтгэж 18-аас дээш насны хүн амыг 2021 оны 07 дугаар сарын 01-ний дотор дархлаажуулж дуусгах,

1.5. Бүх нийтийн бэлэн байдал “Улаан түвшин”-ээс өндөржүүлсэн бэлэн байдлын “Улбар шар” түвшинд шилжих үед халдварын тархалтыг нэмэгдүүлэхгүйн тулд үйл ажиллагааг нь хязгаарлах, зохицуулалтад оруулж үйл ажиллагааг нь нээх аж ахуйн нэгж, байгууллага, бүх төрлийн худалдаа үйлчилгээнд мөрдөх түр стандартыг нэгдсэн байдлаар батлуулж мөрдүүлэх,

1.6. Орон байрандаа эмчлүүлж байгаа иргэдэд Аймаг, нийслэл, дүүргийн Онцгой комиссоос тусгайлан хяналт тавих тогтолцоог бүрдүүлж, халдвар хамгааллыг хэрхэн сахих зөвлөмжийг таниулах ажлыг эрчимжүүлэх,

Хоёр. Улсын онцгой комиссын гишүүн Эрүүл мэндийн сайд, ЗГХЭГ-ын хэвлэл мэдээлэлтэй харилцах газрын дарга, МҮОНРТ-ийн захирал нарт:

2.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын талаарх судалгаа шинжилгээ хийж дүгнэлт гаргах үүрэг бүхий эрдэмтдийн багийн үйл ажиллагааг шинээр байгуулж, олон улсын эрдэмтэн судлаачдын дүгнэлтийг үндэслэн Улсын онцгой комиссыг мэдээллээр хангаж, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх,

2.2. Цар тахлын улмаас учрах аюул, хор холбогдол, халдвар тархах хэлбэр, халдвар хамгааллын дэглэмийн ач холбогдол, оношлогоо эмчилгээний талаар эрдэмтэн судлаач, мэргэжилтнүүдийн хийсэн судалгаа тооцоо, бодит байдлын талаарх мэдээллийг олон нийтэд ил тод, шуурхай мэдээлэх,

2.3. Коронавируст халдвар /Ковид-19/-ын хариу арга хэмжээний нөөцийн ханган нийлүүлэлтийн хомсдлыг даруй шийдвэрлэж, нэн шаардлагатай байгаа нөөц хангалтыг яаралтай хүргүүлж, нийлүүлэлтийн сүлжээг хянах тогтолцоог бэхжүүлэх арга хэмжээ авах,

2.4. Яаралтай түргэн тусламжийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх,

2.5. Суурин болон явуулын шинжилгээний цэгүүдэд шинжилгээний сорьцын нөөц бүрдүүлэх, тандалт, шинжилгээний багийн эмч ажилтнуудыг халдвараас сэргийлэх, шинжилгээний явцын мэдээ мэдээллийг хоног тутам хянаж хатуу зохицуулалтад оруулах,

2.6. Гадаад орноос ирэх иргэд мутацид орсон вирусын тээгч байх эрсдэлээс сэргийлж, өндөр эрсдэлтэй улс орнуудын судалгааг гаргаж Улсын онцгой комиссын гишүүдийг мэдээллээр тогтмол хангаж шаардлагатай арга хэмжээг тухай бүр авах,

2.7. Дархлаажуулалтын хоёр дахь тунг авсан болон өвдөж эдгэрсэн иргэд халдвар авах, бусдад халдвар тархах эрсдэлтэй эсэхийг онолын хувьд нарийвчлан судалж, дүн шинжилгээ хийх,

2.8. Шүлс буюу (цэрэнд) SARS-CoV-2 вирусыг түргэвчилсэн аргаар тодорхойлох оношлуурын стандартыг батлуулах, бусад түргэвчилсэн оношлууртай харьцуулсан туршилт хийж, шинжилгээнд ашиглах,

Гурав. Улсын онцгой комиссын гишүүн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Гадаадын иргэн харьяатын газрын дарга, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал нарт:

3.1. ХӨСҮТ-ийн шинээр баригдсан хүчилтөрөгчийн үйлдвэр, Хан-уул дүүрэг дэх Эх, нярай эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн үндэсний төвийн хүчил төрөгчийн байгууламж, эмнэлгүүдийн хүчил төрөгч дамжуулах дотоод сүлжээ болон аймаг, орон нутагт ашиглаж байгаа хүчил төрөгчийн нөөц, хангамж, аюулгүй байдалд нэгдсэн үзлэг хийх, хүчилтөрөгчөөр тасралтгүй хангах ажлыг зохион байгуулах,

3.2. Халдвараас урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг тогтмол хийж, халдвар тархаж болзошгүй эх үүсвэрүүдийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх,

3.3. Гадаад орноос ирэх иргэд мутацид орсон вирусын тээгч байх эрсдэлээс урьдчилан сэргийлэх асуумжийг нарийвчлан боловсруулах, тусгаарлан ажиглах тухай журамд нэмэлт өөрчлөлт оруулах, хяналт тавьж буй ажилтан албан хаагч нарын ажиллах журмыг шинэчлэн тогтоож мөрдүүлэх,

Дөрөв. Улсын онцгой комиссын гишүүн, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Тагнуулын ерөнхий газрын дарга нарт:

4.1. Эрүүл мэндийн байгууллагын зарим ажилтан албан хаагч нар албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж бусдаас хууль бусаар хээл хахууль авч шинжилгээний хариуг хуурамчаар үйлдсэн, уг мэдээллийг eguul.gerege.mn цахим системд шивж иргэд олон нийтийг халдварт өвчний эрсдэлд оруулсан эсэх асуудлыг 2021 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор шалгаж, холбогдох хариуцлага тооцох,

4.2. Халдварт өвчнийг санаатай болон болгоомжгүй байдлаар тараасан үйлдлийг илрүүлэх, хууль тогтоомжийн дагуу хэрэг бүртгэлийн ажиллагаа хийж холбогдох хуульд зааснаар хариуцлага хүлээлгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах,

Тав. Улсын онцгой комиссын гишүүн, Гадаад харилцааны сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд, Хил хамгаалах ерөнхий газрын дарга нарт:

5.1. Дотоодын халдварын нөхцөл байдал болон нийт хүн амыг дархлаажуулах арга хэмжээ, хөрш орнуудын нөхцөл байдалтай уялдуулан 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс хил нээх боломжийг судлан эрсдэлийн үнэлгээ хийж санал бэлтгэж Улсын онцгой комиссын хуралд танилцуулах.

Зургаа. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захиралд:

6.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакциныг дотооддоо үйлдвэрлэх нөхцөл боломж судалж, биотехнологи инновацийг хөгжүүлэх талаарх мэдээллийг 2021 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор Улсын онцгой комисст танилцуулах,

Долоо. Гадаад харилцааны сайд, Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, Улсын онцгой комиссын Шуурхай штабын дарга нарт:

7.1. Олон улсын хэмжээнд хүүхдүүдийг вакцинжуулах, вакцины сонголтын талаар эрдэмтэн, судлаачдын дүгнэлт танилцуулгыг судалж, дүгнэлт саналыг нэгтгэж танилцуулах.

Найм. Зам, тээврийн хөгжлийн сайд, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга нарт:

8.1. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн цаг хугацаанд авто тээврийн хэрэгслийн зориулалтаар ангилж, замын хөдөлгөөнд QR кодоор оролцуулах зохицуулалтыг боловсронгуй болгох, иргэд хуулийн этгээдэд хүндрэл чирэгдэлгүй ил тод нэгдсэн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах,

8.2. Дархлаажуулалтын 1, 2 дугаар тунг авсан иргэдэд “цахим вакцин паспорт” олгох, бүртгэлийг шуурхай зохион байгуулах,

8.3. Улсын онцгой комиссын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, бие даасан платформыг бий болгох ажлыг эрчимжүүлэх

Ес. Сангийн сайд, Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, Улсын онцгой комиссын Шуурхай штабын дарга нарт:

9.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд заасны дагуу 3 сарын нөөцийн бүрдүүлэлт бий болгох,

9.2. Цар тахлын үед эрсдэл бүхий нөхцөлд үүрэг гүйцэтгэж байхдаа коронавирусын халдвар авсан төрийн албан хаагчдад нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох асуудлыг шийдвэрлэх;

Арав. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга нарт:

10.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэх үйл ажиллагааг хууль, журамд заасан хугацаанд зохион байгуулахад халдвар хамгааллын дэглэм чанд сахиулах, иргэдийг сонгуульд санал өгөх боломж бүрдүүлэх ажлыг хамтран зохион байгуулах,

10.2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагаанд нам эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигч, түүний менежер, шадар туслагч, ухуулагч, ажиглагч сонгуулийн хороодын ажилтан, иргэдийг коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлж, бэлтгэл ажлыг хангуулах,

Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, хурандаа Ж.Амгалан, Улсын онцгой комиссын Шуурхай штабын дарга, хурандаа Ц.Ганзориг нарт үүрэг болгосугай.

ДАРГА



С.АМАРСАЙХАН